

МХБХ-ны Зөвлөлийн 2020 оны 05 дугаар сарын  
27-ны өдрийн 03 тоот тогтоолоор батлав.

## МОНГОЛЫН ХӨЛ БӨМБӨГИЙН ХОЛБООНЫ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ БАЙНГЫН ХОРООДЫН АЖИЛЛАХ ЖУРАМ /2020/

### ДЭД ХЭСЭГ I. ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

#### Нэг. Нийтлэг заалт

- 1.1. Энэхүү журмыг "Монголын хөл бөмбөгийн холбоо" ТББ /цаашид "Холбоо" гэх/-ын Дүрэмтэй нийцүүлэн гаргасан бөгөөд Холбооны Зөвлөлийн дэргэдэх Байнгын хороод /цаашид "Байнгын хороод" гэх/-ын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад тус журмын зорилго оршино.

#### Хоёр. Чиг үүрэг

- 2.1. Байнгын хороод нь Зөвлөлд үүргээ биелүүлэхэд зөвлөж, туслах үндсэн чиг үүрэгтэй. Шаардлагатай тохиолдолд Зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэх асуудлын талаар урьдчилан хэлэлцэж, санал, дүгнэлт гарган Зөвлөлийн хуралд хэлэлцүүлэх, эрхлэх асуудлын хүрээнд Холбооны бодлого, үйл ажиллагааг боловсронгуй болгох санал боловсруулах, Зөвлөлөөс даалгасан ажлыг гүйцэтгэх үндсэн чиг үүрэгтэйгээр ажиллана.

#### Гурав. Байнгын хороод, тэдгээрийн бүрэлдэхүүн

- 3.1. Холбоо нь дараах Байнгын хороодтой байна. Үүнд:
  - 3.1.1. Санхүүгийн хороо;
  - 3.1.2. Аудит, хяналт шалгалтын хороо;
  - 3.1.3. Тэмцээн зохион байгуулах хороо;
  - 3.1.4. Техник, хөгжлийн хороо;
  - 3.1.5. Шүүгчийн хороо;
  - 3.1.6. Эмэгтэйчүүдийн хөл бөмбөгийн хороо;
  - 3.1.7. Хүүхэд залуучуудын хөл бөмбөгийн хороо;
  - 3.1.8. Футзал, Элсний хөл бөмбөгийн хороо;
  - 3.1.9. Тоглогчдын эрх зүйн байдлын хороо.
- 3.2. Байнгын хороодын бүрэлдэхүүнийг Холбооны дүрмээр тодорхойлно.

- 3.3. Аудит, хяналт шалгалтын хорооноос бусад Байнгын хороодыг Зөвлөлийн гишүүд даргалах бөгөөд тэдгээрийг Зөвлөлөөс томилно.
- 3.4. Байнгын хороодын гишүүдийг тухайн хорооны даргын саналыг үндэслэж Зөвлөлөөс батална.
- 3.5. Хороодын гишүүд нь Холбооны Ерөнхий нарийн бичгийн даргын заасан хугацаанд Байнгын хорооны гишүүдтэй холбоотой саналаа бичгээр хүргүүлнэ.
- 3.6. Байнгын хороодын дарга, дэд дарга, гишүүдийг 4 жилийн хугацаагаар томилох бөгөөд дор дурдсан тохиолдолд хугацаанаас нь өмнө чөлөөлж болно. Үүнд:
  - 3.6.1. Өөрөө чөлөөлөгдөх хүсэлт гаргасан;
  - 3.6.2. Тухайн гишүүний харъяалагдах, түүнийг санал болгосон Холбооны гишүүн байгууллага нь Холбооны дүрмийн дагуу гишүүнчлэлээс хасагдсан, чөлөөлөгдсөн;
  - 3.6.3. Эрхэлж буй албан тушаалаар нь Байнгын хорооны гишүүнээр томилсон тохиолдолд тухайн албан тушаалаас чөлөөлөгдсөн;
  - 3.6.4. Ёс зүйн болон сахилга батын ноцтой зөрчил гаргасан;
  - 3.6.5. Хорооны дараалсан 3 удаагийн хуралд оролцоогүй эсхүл бүрэн эрхийн хугацаа дуусаагүй байхад 5 удаагийн хуралд оролцоогүй.
- 3.7. Байнгын хороодын гишүүдийг хугацаанаас нь өмнө чөлөөлсөн тохиолдолд Зөвлөл дараагийн гишүүдийг нөхөн томилно.

### **Дөрөв. Байнгын хороодын ажиллах хэлбэр**

- 4.1. Байнгын хороодын ажиллах үндсэн хэлбэр нь хорооны хурал байна.
- 4.2. Байнгын хороодын дарга нар нь Холбооны Ерөнхий нарийн бичгийн даргатай зөвшилцсэний үндсэн дээр хорооны хурлын товыг тогтооно.
- 4.3. Байнгын хороодын дарга нар өөрсдийн болон хорооны гишүүдийн саналд үндэслэн тухайн хорооны хурлын хэлэлцэх асуудлыг тодорхойлно.
- 4.4. Хэлэлцэх асуудлыг тухайн Байнгын хорооны гишүүдэд хурал болохоос 7 /долоо/ хоногийн өмнө Холбооны Ерөнхий нарийн бичгийн даргаар дамжуулан хүргүүлнэ. Хэлэлцэх асуудлын хамт холбогдох материалыг файлаар хүргүүлнэ.
- 4.5. Хуралд оролцож буй гишүүдийн ердийн олонхийн саналаар хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулж болно. /Ердийн олонх гэдгийг нийт гишүүдийн 50% +1 гишүүн гэж үзнэ./
- 4.6. Хурлын ирц гишүүдийн ердийн олонхи хувь ирсэн тохиолдолд хүчин төгөлдөр байна.
- 4.7. Хурлын шийдвэр нь санал өгөх эрхтэй гишүүдийн ердийн олонх санал өгсөн тохиолдолд хүчин төгөлдөр болно.

- 4.8. Байнгын хорооны хурлыг тухайн Байнгын хорооны дарга даргалж, удирдана. Хуралд Холбооны Ерөнхийлөгч болон Ерөнхий нарийн бичгийн дарга оролцож болно.
- 4.9. Байнгын хорооны хуралд Ерөнхий нарийн бичгийн даргын газраас төлөөлөл оролцож болно.
- 4.10. Хурал бүрийн явцад хурлын тэмдэглэл хөтлөх бөгөөд уг тэмдэглэл нь тухайн Байнгын хорооны дарга гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Байнгын хорооны дарга хурал хуралдсанаас хойш 7 хоногийн дотор Холбооны Ерөнхий нарийн бичгийн даргад хурлын тэмдэглэлийг хүргүүлнэ.
- 4.11. Тодорхой асуудлыг шийдвэрлэх зорилгоор Байнгын хороо бусад байнгын хороодтой хамтран ажиллах эсхүл түр хугацаагаар ажиллах дэд хороо байгуулж болно. Дэд хороодын гишүүдийг Байнгын хорооноос батлах бөгөөд гишүүдийг батлах хүртэл үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 4.12. Байнгын хороод нь Ерөнхий нарийн бичгийн даргын газрын ажилтнуудаас шаардлагатай мэдээллийг гаргуулан авч болно. Мэдээлэл гаргуулан авахдаа Ерөнхий нарийн бичгийн даргаар **дамжуулан албан баримт бичигт үндэслэн авна.**
- 4.13. Байнгын хороод нь шаардлагатай тохиолдолд гадны мэргэжилтнүүдийг ажиллуулж болно.

#### **Тав. Байнгын хороодын дарга нарын эрх, үүрэг**

- 5.1. Байнгын хороодын дарга нар Зөвлөл болон Холбооны бүтцийн бусад байгууллагын өмнө өөрийн хороог төлөөлнө.
- 5.2. **Байнгын хороодын дарга нар өөрийн хорооны хурал болон бусад үйл ажиллагаатай холбоотой аливаа тайланг дараагийн Зөвлөлийн хуралд бичгээр тайлагнана.**
- 5.3. Байнгын хороодын дарга нар өөрийн хорооны хурлыг даргалж удирдах, санал тэнцсэн тохиолдолд шийдвэрлэх санал өгөх, хурлын бэлтгэл ажлыг хангах эрх, үүргийг эдэлнэ.

#### **ДЭД ХЭСЭГ II. БАЙНГЫН ХОРООДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭ**

##### **Зургаа. Санхүүгийн хороо**

- 6.1. Санхүүгийн хороо нь санхүүтэй холбоотой аливаа асуудлаар Зөвлөлд зөвлөх, дэмжих үүрэгтэй байна. Үүнд:
  - 6.1.1. Холбооны санхүүгийн асуудлыг хянах, санхүүтэй холбоотой аливаа асуудлаар Гүйцэтгэх хороонд зөвлөх;

- 6.1.2. Зөвлөл болон Их хуралд өргөн барих Холбооны Ерөнхий нарийн бичгийн даргын боловсруулсан төсөв ба санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийх;
- 6.1.3. Батлагдсан төсөв болон жилийн санхүүгийн тайланг Зөвлөлд танилцуулах;
- 6.1.4. Санхүүтэй холбоотой бусад асуудлыг зохицуулах.

### **Долоо. Тэмцээн зохион байгуулах хороо**

- 7.1. Тэмцээн зохион байгуулах хороо нь МХБХ-ноос зохион байгуулах тэмцээнүүдийг чанаржуулах, өсгөн нэмэгдүүлэх бодлогыг боловсруулах, тэмцээн зохион байгуулах хэлтсийг удирдлагаар хангах үндсэн чиг үүрэгтэй бөгөөд энэхүү чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
  - 7.1.1. Холбооны дүрэмд заасны дагуу Холбооны зохион байгуулдаг тэмцээн, тоглолттой холбоотой асуудлыг зохион байгуулах;
  - 7.1.2. Тэмцээнээр дамжуулж Холбоог сурталчлах;
  - 7.1.3. Холбооны тэмцээн уралдаантай холбоотой асуудлыг зохицуулах;
  - 7.1.4. Тэмцээнүүдийн төрөл хэлбэр, бодлого, чанарыг тодорхойлох.

### **Найм.Техник, хөгжлийн хороо**

- 8.1. Техник, хөгжлийн хороо дараах үүрэгтэй. Үүнд:
  - 8.1.1. Монголын хөл бөмбөгийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, түүнтэй холбоотой бүхий л асуудлыг боловсруулж Зөвлөлд санал оруулах;
  - 8.1.2. Хөл бөмбөгийн үндсэн асуудлуудтай холбоотой дүн шинжилгээ хийх, хөгжлийн хөтөлбөр боловсруулах / Шигшээ багууд, грассрүүтс, өсвөрийн хөл бөмбөг/ хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих;
  - 8.1.3. Хөл бөмбөгийн салбарт боловсролын бодлогыг дэмжих хөтөлбөрийг боловсруулах, цогц сургалтын системийг бий болгож хэрэгжүүлэх;
  - 8.1.4. Хөл бөмбөг дэх эрүүл, шударга тоглолтын орчинг бүрдүүлэх боломжийг судлах;
  - 8.1.5. Хөл бөмбөгийн хөгжлийн шинэ үйл ажиллагааг санал болгох ;
  - 8.1.6. Шигшээ багийн дасгалжуулагчийн сонгон шалгаруулалтанд санал өгөх;
  - 8.1.7. Шигшээ багийн дасгалжуулагчийн үйл ажиллагааг дэмжих, заавар, чиглэл, зөвлөмж өгөх;
  - 8.1.8. Шигшээ багийн тамирчдын сонгон шалгаруулалт болон бэлтгэлжилтийг хянах.

## **Ес. Шүүгчийн хороо**

- 9.1. Шүүгчийн хороо нь ОУХБХ, МХБХ-ны Шүүгчийн хорооны дүрэмд зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 9.1.1. Холбооны шүүгчдийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлтийн бодлогыг боловсруулах;
  - 9.1.2. Шүүгчийн хэлтсийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, шүүгчийн хэлтсийн үйл ажиллагаанд хяналт тавих;
  - 9.1.3. ОУХБХ-ны Тоглолтын дүрмийг мөрдүүлэх;
  - 9.1.4. Шүүгчийн хэлтсийн саналыг үндэслэн дотоодын болон олон улсын тэмцээн шүүх, сургалт, уулзалтад хамрагдах шүүгчдийн томилгоог батлах;
  - 9.1.5. Шүүгчийн сургалт зохион явуулах боломжтой чадварлаг боловсон хүчин /сургагч багш/-ийг болон шүүгчдийн ажил үүрэгт үнэлэлт дүгнэлт өгч, чадваржуулах үүрэг бүхий хянагч шүүгчдийг бэлдэн гаргах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
  - 9.1.6. Шүүгчдийн ажил үүргээ гүйцэтгэх таатай орчныг хангуулах, мөн шаардлага хангасан зохих хувцас хэрэгсэл, эд материал ашиглуулах талаар Зөвлөл болон бусад холбогдох хороо, хэлтэст санал, шаардлага хүргүүлэх.

## **Арав. Эмэгтэйчүүдийн хөл бөмбөгийн хороо**

- 10.1. Эмэгтэйчүүдийн хөл бөмбөгийн хороо дараах үүрэгтэй. Үүнд:
- 10.1.1. Холбооны Дүрэмд заасны дагуу эмэгтэйчүүдийн хөл бөмбөгтэй холбоотой аливаа асуудлыг зохицуулах;
  - 10.1.2. Охид, эмэгтэйчүүдийн хөл бөмбөгийн хөгжлийн стратеги бодлогыг боловсруулах, тэмцээн уралдааны зохион байгуулалт, зааврын талаар санал боловсруулан холбогдох хэлтэст шилжүүлэх;
  - 10.1.3. Монголын эмэгтэй хөл бөмбөгийн тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, залгамж халааг бэлдэх, Ази тив болон Олон улсын жишигт хүргэх боломжит хөтөлбөр, бодлого стратегийг боловсруулж, Зөвлөлд санал оруулж хэрэгжүүлэх.

## **Арван нэг. Футзал, элсний хөл бөмбөгийн хороо**

- 11.1. Футзал, элсний хөл бөмбөгийн хороо дараах үүрэгтэй. Үүнд:
- 11.1.1. Футзал ба элсний хөл бөмбөгтэй холбоотой аливаа асуудлыг зохицуулах;
  - 11.1.2. Холбооны футзал ба элсний хөл бөмбөгийн тэмцээнүүдийн талаар зөвлөх үүрэгтэй оролцох;

- 11.1.3. Холбооны футзал ба элсний хөл бөмбөгийн тэмцээнүүдтэй холбоотой аливаа асуудлыг хэлэлцэх;
- 11.1.4. Монголын футзалын тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, залгамж халааг бэлдэх, Ази тив болон Олон улсын жишигт хүргэх боломжит хөтөлбөр, бодлого стратегийг боловсруулж, Зөвлөлд санал оруулж хэрэгжүүлэх.

### **Арван хоёр. Хүүхэд залуучуудын хөл бөмбөгийн хороо**

- 12.1. Хүүхэд залуучуудын хөл бөмбөгийн хороо нь дараах үндсэн үүрэгтэй. Үүнд:
  - 12.1.1. Хүүхдийн хөл бөмбөгтэй холбоотой аливаа асуудлыг зохицуулах;
  - 12.1.2. Холбооны хүүхдийн хөл бөмбөгийн тэмцээнүүдэд зөвлөх үүрэгтэй оролцох;
  - 12.1.3. Холбооны хүүхдийн хөл бөмбөгийн тэмцээнтэй холбоотой аливаа асуудлыг хэлэлцэх;
  - 12.1.4. Монголын өсвөрийн хөл бөмбөгийн хөгжлийн чиг хандлага, бодлогыг тодорхойлох.

### **Арван гурав. Тоглогчдын эрх зүйн байдлын хороо**

- 13.1. Тоглогчдын эрх зүйн байдлын хороо нь ОУХБ/МХБХ-ны Тоглогчийн статус ба шилжилт хөдөлгөөний журамд зааснаас гадна дараах үндсэн үүрэгтэй. Үүнд:
  - 13.1.1. Тоглогчдын шилжилт хөдөлгөөнд зохих журмын дагуу хяналт тавих;
  - 13.1.2. Холбооны тэмцээнд оролцож байгаа тоглогчдын эрх зүйн байдлыг зохих журмын дагуу тодорхойлох.

### **Арван дөрөв. Аудит, хяналт шалгалтын хороо**

- 14.1. Аудит, хяналт шалгалтын хороо нь МХБХ-ны дүрэмд зааснаас гадна дараах үүрэгтэй байна. Үүнд:
  - 14.1.1. Эрсдлийг тооцох, эрсдлийн зохицуулалт болон дотоод хяналтын системийн хэрэгжилтийг жил бүр үзэж танилцах;
  - 14.1.2. Дотоод аудитын үйл ажиллагааг үр дүнтэй байгаа эсэхийг тодорхойлох ;
  - 14.1.3. Холбооны санхүүд хяналт тавих;
  - 14.1.4. Татвартай холбоотой асуудлыг шалгах;
  - 14.1.5. Нягтлан бодох бүртгэлийн стандартыг хэрэгжүүлэх;
  - 14.1.6. Санхүүгийн тайланг батлахтай холбоотойгоор Санхүүгийн хороо болон Зөвлөлд зөвлөгөө өгөх;

- 14.1.7. Монгол Улсын санхүү, нягтлан бодох бүртгэл, татвартай холбоотой хууль тогтоомжууд болон ОУХБХ, АХБХ-ны зохих аудитын журамд нийцүүлэн ажиллаж байгаа эсэхийг хянах.
- 14.2. Аудит, хяналт шалгалтын хороо нь дарга, дэд дарга ба гишүүдээс бүрдэх бөгөөд эдгээр нь Холбооны Зөвлөл болон бусад гишүүн байгууллагуудаас хараат бус бие даасан байна.
- 14.3. Тус хорооны гишүүд нь тухайн салбартаа мэдлэг туршлагатай этгээд байх бөгөөд Холбооны үйл ажиллагаанд харшлахааргүй шийдвэр гаргах үүрэгтэй.
- 14.4. Аудитын хорооны дарга нь Холбооны Их Хурал, Ерөнхийлөгч, Зөвлөлд өөрийн хороог төлөөлөх бөгөөд түүний эзгүйд хорооны Дэд дарга төлөөлнө.
- 14.5. Хорооны дарга Холбооны удирдах албан тушаалтан болон хөндлөнгийн аудиторуудтай тодорхой хугацаанд тусдаа уулзалт ярилцлага зохион байгуулж болно.
- 14.6. Зөвлөлийн хүсэлтийн дагуу Хорооны дарга нь өөрийн хорооны үйл ажиллагааны тайланг Их хуралд тайлагнах үүрэгтэй бөгөөд уг тайланг бичгээр Ерөнхийлөгч болон Зөвлөлд хүргүүлнэ.
- 14.7. Шаардлагатай тохиолдолд Ерөнхий нарийн бичгийн даргаас улирлын санхүүгийн тайлан мэдээг гаргуулан авч болно.

#### **Арван тав. Бусад зүйл**

- 15.1. Энэ Журмаар зохицуулагдаагүй байнгын хороодын үйл ажиллагаатай холбоотой бусад харилцааг Холбооны дүрмийг удирдлага болгон зохицуулна.
- 15.2. Энэхүү Журмыг МХБХ-ны Зөвлөл баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

Улаанбаатар хот  
2020 оны 05 дугаар сарын 27-ны өдөр